



## **СОНОМЫН ЛУВСАНГОМБО**

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга  
1971-1972 он

Хуучин Түшээт хан аймгийн Хутаг уулын хошуу одоогийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт 1924 онд төрсөн. 20 нас хүртэл эцэг эхийн гар дээр хүмүүжиж мал маллаж байгаад бүлгэмд суралцаж бичиг үсэгтэй болжээ.

1944 онд ардын цэрэгт татагдан Сайншандад хуягт бригадад цэрэг, тасгийн дарга хийж байгаад 1944-1948 онд ЗХУ-д Артиллерийн техникийн дунд сургууль, 1948- 1954 онд Москва хотын Артиллерийн инженерийн академид, 1960-1965 онд ЗХУ-д Барилгын инженерийн дээд сургуульд эчнээ суралцаж барилгын инженер- технологичийн мэргэжил эзэмшсэн байна.

1948 онд Цэргийн яамны бууны үйлдвэрт зэвсгийн техникч, 1954-1956 онд Цэргийн ерөнхий сургуульд багш, 1956-1959 онд Барилгын сантехникийн газар ерөнхий инженер, 1959 онд МАХН- ийн Төв Хороонд зааварлагч, нарийн бичгийн даргын туслах, 1959-1964 онд Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны орлогч сайд, нэгдүгээр орлогч сайд 1964-1968 он хүртэл Улсын барилгын зөвлөлийн орлогч дарга, 1968-1971 онд Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны орлогч сайдаар ажиллаж байгаад.

1971-1972 онд Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны дарга, 1972-1982 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Барилгын архитектурын комиссын дарга, Барилга архитектур, техник хяналтын улсын хорооны даргаар хавсран ажиллаж, 1982-1984 онд НАХЯ-ны сайд, 1984-1989 онд Сайд нарын Зөвлөлийн орлогч даргын алба хашиж байгаад тэтгэвэрт гарчээ.

С.Лувсангомбо МАХН-ын XVI, XVII, XVIII, XIX их хуралд төлөөлөгчөөр оролцож, Намын Төв Хорооны гишүүн, 1982 онд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны орлогч гишүүнээр сонгогдож байв. Мөн БНМАУ-ын АИХ- ийн 7, 8, 9, 10 дах удаагийн сонгуулиар БНМАУ-ын АИХ- ийн депутатаар сонгогджээ. 1979-1982 онд Монгол-Вьетнам, Монгол-Лаос, 1984 оноос хойш Монгол-Унгар, Монгол-Германы Засгийн газар хоорондын Эдийн засаг, шинжлэх ухаан техникийн талаар хамтран ажиллах комиссын Монголын хэсгийн даргаар ажиллаж байв. Тэрбээр нийслэл хотын барилга, инженерийн шугам сүлжээг өргөтгөх, орон сууц үйлчилгээний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах талаар анхаарч нэлээд ажлыг зохион байгуулжээ.

Түүний ажлын амжилт бүтээлийг төр засаг өндрөөр үнэлж "Сүхбаатарын одон", "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон", "Байлдааны гавьяаны одон", "Хөдөлмөрийн хүндэт медаль", бусад ойн медалиудаар шагнаснаас гадна ЗХУ, Чех, Куба, Болгар, БНАГУ-ын одон медалиудаар шагнаж байжээ